



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 19/482

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хооронд орсон их хэмжээний аадар борооноос үүссэн үерийн аюулын улмаас учирсан хохирлыг арилгахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд зарцуулах 6,492,580, (зургаан сая дөрвөн зуун ерөн хоёр мянга таван зуун наян) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0948

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар  
сарын 07-ны өдрийн 07 дугаар  
захирамжийн хавсралт



### ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ, МАТЕРИАЛ

1	Шатахуун	404 литр	2670	997,880
2	Шатахуун	190 литр	3660	695,400
3	Ус соруулах помп	4 ширхэг	550,000	2,200,000
4	Зил -131 сэлбэг (кольц, жийрэг, слкон, клинGRID, мовьт шаариг)	1	996,500	996,500
5	Зил-131 мотор цэвэрлэж, боолгох	1	860,000	860,000
5	Зил-131 масло, тосол, таб, гидрийн шингэн, цэвэрлэх бодис	1	742,800	742,800
Нийт үнэ				6,492,580

-oOo-